



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/156

Хэрлэн сум

2019 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг
зохион байгуулж явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай тухай хуулийн 12, 13 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны мн/135 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг 04 дүгээр сарын 22-ноос 5 дугаар сарын 08-ны хооронд явуулсугай.

2. 2019 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын товчоог дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Товчооны дарга:	Ж.Ганбаатар	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга:	Н.Хүрэлээ	-Цэргийн штабын дарга, хурандаа
Гишүүд:	Н.Чанцал	-Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа
	Ж.Болд	-Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа
	Б.Хуягбаатар	-Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа
	Ц.Гэрэлмаа	-Эрүүл мэндийн газрын дарга
	Ц.Баярмаа	-Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
	Г.Дашдаваа	-Насан туршийн боловсролын "Гэгээрэл" төвийн захирал
	Ц.Идэрбат	-Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
Нарийн бичгийн дарга:	Л.Цэнддорж	-Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицер, хошууч

3. Цэрэг татлагын хуваарийг 1 дүгээр, зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. 2019 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар Зэвсэгт хүчний Жанжин штабаас тогтоосон хяналтын тоог баримтлан хуульд заасан шаардлага хангасан залуучуудыг

2//.

хугацаат цэргийн албанд татаж, 5 дугаар сарын 05-нд багтаан алба хаах цэргийн ангиудад хүлээлгэн өгч, дүнг 5 дугаар сарын 10-нд танилцуулахыг Цэрэг татлагын товчоо/Ж.Ганбаатар/-нд үүрэг болгосугай.

5 Зэвсэгт хүчний Жанжин штабаас тогтоосон хяналтын тоог баримтлан 19-29 насны хугацаат цэргийн алба хаасан, гэрээт цэргийн албанд элсэх хүсэлтэй залуучуудыг журмын дагуу сонгон шалгаруулж, бичиг баримтыг бүрдүүлэн Зэвсэгт хүчний Төв дамжин өнгөрүүлэх баазад хүргүүлэхийг Цэрэг татлагын товчоо/Ж.Ганбаатар/-нд даалгасугай.

6 Цэрэг татлагын үед мэргэжлийн эмч нарын үзлэгийг "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ын дагуу шинжилгээ, оношлогоог үндэслэн чанартай явуулах, эмчлэгдэн эдгэрэх боломжтой залуучуудыг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар /Ц.Гэрэлмаа/-т, цэргийн албанд татагдагсдын боловсролын түвшинг харгалзан үзэх, бичиг үсэг үл мэдэгч, бага боловсролтой иргэдийг албан бус сургалтад хамруулан боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Насан туршийн боловсролын "Гэгээрэл" төв /Г.Дашдаваа/-д, Цэргийн албанд татагдагсдын гэмт хэрэг зөрчилд холбогдож байсан эсэхийг хянах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Ж.Болд/-т, цэрэг татлагын байрны дотоод дэг журам сахиулах, цэрэг татлагын товчооны ажилд дэмжлэг үзүүлэхийг Онцгой байдлын газар /дэд хурандаа Н.Чанцал/-т тус тус үүрэг болгосугай

7. Зарлан дуудах хуудсыг нэрсийн жагсаалтад орсон цэргийн албанд татагдагч бүрт хүргүүлэн, заасан хугацаанд Цэрэг татлагын байранд бэлэн байлгах, тэдний бичиг баримтыг бүрдүүлэх, сумын эрүүл мэндийн төвд цусны бүлэг тогтоох, хэвлийн чанд авиан оношлогоо, шээсний шинжилгээг урьдчилан хийсэн байх, Цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг ажиллах нөхцөл, хоол хүнсээр хангах, Цэргийн албанд татагдагсдыг үдэж мордуулах, цэргийн албанаас халагдан ирж буй дайчдыг угтан авах, тэднийг ажлын байранд зуучлах ажлыг сахилга, зохион байгуулалтын өндөр хэмжээнд зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. 2019 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын товчоо, зохион байгуулах бие бүрэлдэхүүнийг үүрэг даалгавраар хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, цэргийн албанд татагдагсдыг аймгийн цэрэг татлагын байранд ирүүлэх, цэргийн албанаас халагдагсдыг бичиг баримттай нь хүлээн авч, цэргийн тоо бүртгэлд тусган, сумдын ЗДТГ-ын дарга нарт хүлээлгэн өгч, орон нутагт хүргэх ажлыг зохион байгуулахыг Цэргийн штаб /хурандаа Н.Хүрэлээ/-т даалгасугай.

9. 2019 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлага зохион байгуулахад шаардагдах 5978270 /таван сая есөн зуун далан найман мянга хоёр зуун далан / төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Цэрэг татлагын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



Аймгийн Засаг даргын 2019 оны 24 дугаар сарын 03 өдрийн 7/156 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



2019 ОНЫ 1 ДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Сум, багийн нэр	Үзлэгээр орох хүний тоо	Тэнцүүлэн татах хүний тоо	Цэрэг татлагад орох газар	Үзлэгт бэлэн байх	
					Сар өдөр	Цаг
1.	Өлзийт	45	3	Өлзийт	04.22	09.00
2.	Өмнөдэлгэр	237	13	Өмнөдэлгэр	04.22	13.00
3.	Гурванбаян	40	3	Гурванбаян	04.23	09.00
4.	Батширээт	114	7	Батширээт	04.23	14.00
5.	Биндэр	212	13	Биндэр	04.24	09.00
6.	Баян-Адарга	128	8	Баян-Адарга	04.24	15.00
7.	Дадал	128	8	Дадал	04.25	09.00
8.	Норовлин	116	7	Норовлин	04.25	14.00
9.	Баян-Овоо	104	6	Баян-Овоо	04.26	09.00
10.	Батноров	168	10	Батноров	04.26	13.00
11.	Бэрх	134	8	Бэрх	04.27	09.00
12.	Хэрлэн	960	60	Хэрлэн	04.29	09.00
13.	Баянхутаг	3	1	Хэрлэн	04.30	09.00
14.	Галшар	3	1			
15.	Бор-Өндөр	9	1			
16.	Дархан	2	1			
17.	Баянмөнх	2	1			
18.	Дэлгэрхаан	4	1			13.00
19.	Хэрлэнбаян-Улаан	2	1			
20.	Цэнхэрмандал	4	1			
21.	Жаргалтхаан	5	1			
22.	Мөрөн	3	1			
	Нийт дүн	2423	146			

2019 ОНЫ 1 ДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Төсөвлөсөн	Хянасан	Тайлбар
1	Хоолны зардал	1260000		
2	Томилолт, урамшуулалын зардал	1986000		
3	Бичиг хэрэг, рентгэн, шинжилгээний бодис	445000		
4	Шатахууны зардал	2287270		
	Нийт	5978270		

Нэг. Хоолны зардал

№	Сар өдөр	Хоолох хүний тоо	Салат		Хоол		Нийт үнэ
			Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	
1	04/30	40	3000	120000	6000	240000	360000
2	05/01	40	3000	120000	6000	240000	360000
3	05/02	30	3000	90000	6000	180000	270000
4	05/03	30	3000	90000	6000	180000	270000
				480000		780000	1260000

Хоёр. Томилолт, урамшууллын зардал

№	Газрын нэр	Хүний тоо	1 хоногийн томилолт	Хоног	Мөнгөн дүн
1	Сумдаар	10	26500	5	1325000
2	УБ хотод	3	69000	3	621000
3	Урамшуулал	2	20000	1	40000
	Дүн				1986000

Гурав. Бичиг хэрэг, рентгэн шинжилгээний бодис

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо	Мөнгөн дүн
1	Анонс	М.кв	8000	9	56000
2	Цаас	боодол	9000	1	9000
3	Принтерийн хор	ш	10000	1	10000
4	Рентгэн, шинжилгээний бодис	хүн	2000	190	380000
	Дүн				445000

Дөрөв. Шатахууны зардал

№	Сумын нэр	Машины марк	Тос	Явах км	Зарцуулах шатахуун	Нийт үнэ
1.	Цэрэг татлагын товчоо	Пургон	1	757	120	209400
		Бенз 250	1	850	127	303530
1.	Өлзийт	Пургон	1	100	18	31410
2.	Өмнөдэлгэр	Пургон	1	200	36	62820
3.	Гурванбаян	Пургон	1	260	47	82015
4.	Батширээт	Пургон	1	380	68	118660
5.	Биндэр	Пургон	1	360	65	113425
6.	Баян-Адарга	Пургон	1	320	57	99465
7.	Дадал	Пургон	1	540	98	171010
8.	Норовлин	Пургон	1	400	72	125640
9.	Батноров	Пургон	1	200	36	62820
10.	Баян-Овоо	Пургон	1	270	48	83760
11.	Бэрх	Пургон	1	140	25	43625
12.	Хэрлэн	Пургон	1	100	18	31410
13.	Баянхутаг	Пургон	1	50	9	15705
14.	Галшар	Пургон	1	290	52	90740
15.	Бор-Өндөр	Пургон	1	370	67	116915
16.	Дархан	Пургон	1	290	52	90740
17.	Баянмөнх	Пургон	1	200	36	62820
18.	Дэлгэрхаан	Пургон	1	290	52	90740
19.	ХБулаан	Пургон	1	360	64	111680
20.	Цэнхэрмандал	Пургон	1	290	52	90740
21.	Жаргалтхаан	Пургон	1	200	36	61200
22.	Мөрөн	Пургон	1	60	10	17000
						2287270